



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/А75

Булган сум

“Лэнд тест” ХХК-тай гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Засгийн газрын 2019 оны “Дүрэм шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 108 дугаар тогтоолын хавсралтын 3.12 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Х/74 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 2.14, аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/563 дугаар захирамжийн хавсралтын 29 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган сумын Ерөнхий боловсролын нэгдүгээр сургуулийн 960 хүүхдийн өргөтгөлийн шинэ сургууль, Тэшиг сумын дотуур байр, Булган сумын төв халуун усны барилгын инженер геологийн судалгааны ажлыг 19,690,000 (арван есөн сая зургаан зуун ерэн мянга) төгрөгөөр “Лэнд тест” ХХК-тай гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Лэнд тест” ХХК-ийн захирал (И.Сайнсанаа)-д үүрэг болгосугай.

3.Дээрх инженер геологийн судалгааны ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж хүлээн авахыг аймгийн Ерөнхий архитектор (М.Цэрэнчимэд)-д даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний “Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулах зардал” санхүүжүүлэхийг

03.15.11.009

Булган Ажил 2025 өдөр Өвд Досг 2025 захирамж

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР